

Халамжийн Бус Эцэг Эхийн Эрх Үүрэг Noncustodial Parent's Rights and Responsibilities

Хүүхдийн Халамжийн Хэлтэс (DCS):

1. Хүүхдийн халамжийн ордер гаргах, эрүүл мэндийн халамжийн төлбөрийг албадан хэрэгжүүлэх.
2. Хүүхдийн халамжийн ордерийг хянах, шаардлагатай өөрчлөлтийг хийх.
3. Хүүхдийн халамжийн мөнгийг хүлээн авах, баримтжуулах болон Вашингтон Мужийн Халамжийн Бүртгэлийн (WSSR) шугамаар тараах.

Халамжийн Бус Эцэг Эх

Та бол халамжийн бус эцэг/эх. Халамжийн бус эцэг/эх гэдэг нь харгалзаж буй хүүхэддээ санхүүгийн туслалцаа үзүүлэх ёстой төрөлхийн эсвэл шүүхийн шийдвэрээр болон албан ёсоор өргөж авсан аав эсвэл ээжийг хэлнэ. Улсын болон холбооны хуульд үүнийг тулган заасан байдаг.

Хүүхдийн Халамжийн Төлбөр

Ихэвчлэн та хүүхдийн халамжийн төлбөрийг төлөх ёстой байдаг. DCS танд хүүхдийн халамжийн төлбөр төлөхийг шаардсан мэдэгдэл явуулсны дараа DCS нь таны WSSR, өөр мужийн шүүхийн болон хүүхдийн халамжийн агентлагийн дансаас бусад өөр хэнд ч төлсөн төлбөрийг **тооцохгүй**. Нийгэм Хангамжын Удирдах Газар, Хөдөлмөр, Аж Үйлдвэрийн Яам юмуу Ахмад Дайчдын Хэрэг Эрхлэх Яам зэрэг газраас төлсөн хүүхдийн тэтгэмжээс бусад тохиолдолд нөгөө талын этгээдэд хүүхдийн тэтгэмж болгон шууд төлсөн төлбөрийг DCS хүлээн зөвшөөрөхгүй.

1. Хэрэв таныг өөр мужийн эсвэл овгийн хүүхдийн халамжийн төв эсвэл мужын болон улсын шүүх төлбөр төлөхийг шаардсан бол түргэн DCS-д мэдэгдэх ёстой.
2. DCS таныг тодорхой бичсэн хаягаас өөр хаяр руу төлбөр хийхийг хүссэн тусгай нууцлалтай захиа авснаас өөр үед WSSR-ийн жагсаалтанд орсон хаягаас өөр газар руу төлбөр хийж болохгүй.

Бүх төлбөр тооцоог Вашингтон Мужийн Халамжийн Бүртгэл (WSSR) уруу явуулах. Дараах маягаар төлбөр барагдуулж болно.

1. Цалингаас Суутгах. Ихэнхи халамжийн ордер нь DCS-ийг цалингийн суутгал хийх болон WSSR-аар дамжуулж хийхийг зөвшөөрдөг. Хэрэв таны ордер үүнийг зөвшөөрч байвал DCS нь цалингаас тань суутгах болно.
2. Хувийн чек, мөнгөний ордер, баталгаат чек болон кассын чек. Бүх мөнгөний ордер болон чекийг дараах хаяг руу илгээнэ үү:

WASHINGTON STATE SUPPORT REGISTRY
PO BOX 45868
OLYMPIA WA 98504-5868

3. Цахилгаан Хөрөнгийн Шилжүүлэг (EFT). Цахим хөрөнгийн шилжүүлэг/EFT/-ны сар бүр харилцах данс болон хадгаламжийн дансанаас автоматаар дэмжлэг үзүүлэх нөхөн төлбөрийг хасч байна. Дэлгэрэнгүй мэдээлэл хүсвэл, 800-468-7422 утсаар асуун уу.
4. Интернет. Онлайн төлбөрөөр харилцах данс болон хадгаламжийн дансанаас автоматаар дэмжлэг үзүүлэх нөхөн төлбөрийг хасч болно. Дэлгэрэнгүй мэдээллийг DCS вэб хуудаснаас авна уу: <https://secureaccess.wa.gov>.
5. Кредит буюу дебит карт. Дэлгэрэнгүйг DCS-ийн вэб хуудаснаас авна уу: <https://www.dshs.wa.gov/esa/division-child-support/creditdebit-card-payments>.

Хэрэв банк таны явуулсан чекийг буцаасан, хангалттай мөнгө хүрэлцээгүйгээс EFT болон интэрнет суутгалын аргыг зөвшөөрөөгүй бол DCS нь цаашид бүх төлбөрөө зөвхөн бэлэн мөнгө, кассийн чек, цалингийн суутгал, мөнгөний ордероор авах болно.

Дансны дугаараа **IN** _____ бүх төлбөр, харилцаанд оруулж бичнэ үү.

Хэрвээ та хүүхэддээ санхүүгийн тэтгэмж өгөхгүй байх эрх зүйн шалтгаантай юмуу эсвэл DCS алдаа гаргаж таныг энэ асуудалд оролцуулж байвал DCS-т нэн даруй мэдэгд.

Тэтгэмж өгөх үүргийг тань бид зогсоож буй талаар DCS мэдэгдсэн байлаа ч ирээдүйд таны энэ үүргийг сэргээх боломжтой юм. DCS ийм арга хэмжээ авахаас өмнө танд мэдэгдэнэ.

Хэрвээ та зургаан сараас илүү хугацаанд эрх чөлөөгөө хорих газар, шорон эсвэл засан хүмүүжүүлэх байранд хоригдож хязгаарлуулах бол, таны хүүхдийн тэтгэмж хүүхэд бүрийн тэтгэмжийн тушаалаар сар бүр \$10-аар түр хугацаанд багасах (буурах) болно. Та, асрамжлах эцэг эх, эсвэл DCS нь хэмжээг бууруулахыг шаардаж болно. Хэрвээ таны хэрэгт тэтгэмж буурах боломжтой бол та DCS-аас буурах хугацааг тайлбарласан мэдэгдэл авах бөгөөд хэрвээ тэд зөвшөөрөхгүй бол оролцогч хүн бүр шүүх хурлаар асуудлыг шийдүүлэх эрхтэй. Хэмжээ нь таныг суллагдсанаас дөрвөн сард 50%-р дээшлэх ба суллагдсанаас нэг жилийн дараа буцаж 100%-р ихсэж хэвийн хэмжээнд орох болно.

Эрүүл Мэндийн Халамжийн Хариуцлага

Хэрэв таны халамжийн ордер таныг хүүхдийнхээ эрүүл мэндийн даатгалыг төлөхийг шаардсан бол нь таны хариуцлагыг хүлээлгэхийн тулд DCS албадах болно. Хэрэв таны халамжийн ордер таныг бэлэн мөнгөөр эмнэлгийн тусламжийг төлөхийг шаардсан бол DCS нь хэдэн доллар төлөхийг тогтоон танаас авах болно.

1. Халамжийн ордер дээр бичигдсэн хүүхдийн эрүүл мэндийн даатгалын талаар ямар нэг мэдээлэл өөрчлөгдсөн бол нэн даруй мэдэгдэнэ үү.
2. Хэрэв эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй бол, эмнэлгийн халамжийн бэлэн мөнгөний төлбөр нь эргүүлж аваагүй эмнэлгийн төлбөр болон эмнэлгийн хувьцааны нэмэгдэл төлбөртэй тэнцүү байна.

Хэрэв таны халамжийн ордер халамжийн эцэг эхээр нь хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг эсвэл даатгалгүй эмнэлгийн зардлыг төлүүлэхийг шаардсан бол та хүүхдийн бүрэн халамжийн үйлчилгээний төвд хандан:

1. DCS - ээр халамжийн эцэг эхээр нь эрүүл мэндийн даатгалыг төлүүлэхийг шаардуулах. Таны асуудлын нөхцөл байдлыг судалсны эцэст DCS нь шаардлагатай арга хэмжээг авах болно.
2. WAC 388-14A-1020 дагуу халамжийн эцэг эхээс нь даатгалгүй эмнэлгийн зардал, нэмэлт төлбөр, хасч болохоор зардал, төлбөрийг төлүүлэхийг DCS - ээр шаардуулах.

Хэрэв таны халамжийн ордер халамжийн эцэг эхээр нь хүүхдийн эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн нэмэлт төлбөр эсвэл даатгалгүй эмнэлгийн зардлыг төлүүлэхийг WAC 388-14A-1020 дагуу шаардаагүй бол та DCS руу хандан ордертоо өөрчлөлт хийхийг хүсэх буюу өөрөө өөрчлөх өргөдөл гаргаж болно.

Эсэргүйцлийн хувилбарууд

Удирдах Зөвлөлийн Хурал. Удирдах Зөвлөлийн Хурал нь асуудал шийдвэрлэх, бодлогын тайлбар өгөх, баримтыг баталгаажуулах зорилготой DCS-ийн удирдлагын (шүүхийн бус) процесс юм.

1. Удирдах Зөвлөлийн Хурал нь хүүхдийн халамжийн талаарх шүүхийн болон шүүхийн бус аль ч асуудлыг хэлэлцэж болно.
2. Удирдах Зөвлөлийн Хурал нь танд мэдэгдэлгүй шийдэлд хүрч болно. Хэрэв та уулзалт тохирсон бол асуудлаа DCS-ийн өмнөх шийдвэрийг цуцлах чадалтай менежментийнхэнтэй асуудлаа ярилцах хэрэгтэй. DCS-ийн Удирдах Зөвлөл нь компаний зарим ажилчдын хийсэн алхмыг өөрчилж чадах ч хуулийн дагуух үйлдэлд өөрчлөлт оруулж чадахгүй.

Хөндлөнгийн үйл ажиллагаа (хуулийн байцаалт). Энэ хуулийн байцаалт нь мөн шүүхийн бус удирдлагын процесс юм. Энэ хурал нь Удирдах Зөвлөлийн Хурлаас илүү чухал ч шүүхийн актаас бага албаных юм.

1. Мужийн хуулийн дагуу маш цөөн тохиолдолд л хуулийн байцаалтаар шийдвэрлүүлдэг. DCS нь танд мэдэгдэл явуулахдаа хуулийн байцаалтаар шийдвэрлүүлэх эрх байгаа эсэхийг тодорхойлох болно. Удирдлагын Хуулийн Шүүгч (ALJ) хуулийн байцаалт дээр байх болно. ALJ нь DCS-ийн ажилчид биш юм.
2. Хуулийн байцаалтын үеэр таны асуудалтай танилцаж хянах болно. DCS-ийг таны хүүхдийн халамжийн ордерийг албадхыг зогсоохыг хүсвэл та хуулийн байцаалтыг 20 хоногийн (Вашингтон Мужид энэхүү мэдэгдлийг хүлээн авсан бол) 60 хоногийн дотор (Вашингтон Мужиаас өөр газар энэхүү мэдэгдлийг хүлээн авсан бол) өргөдөл гарах хэрэгтэй.
 - a. Та 20-60 хоногийн дотор л хуулийн байцаалт авахыг хүсч болно. Гэхдээ хуулийн байцаалт дуустал DCS нь таны халамжийн ордерийг албадах болно. DCS нь хуулийн байцаалтын үед цуглуулсан мөнгөнөөс танд буцааж өгөхгүй гэдгийг анхаарна уу.
 - b. Хэрэв та энэ мэдэгдлийг авсны жилийн дараа хуулийн байцаалт авахыг хүсч байгаа бол хүндэтгэх шалтгаан (удсан шалтгаан) дурьдаж батлах баримт үзүүлэх ёстой. ALJ нь таны хоцорсон хүсэлтийг үгүйсгэж магадгүй. Гэхдээ танд хуулийн байцаалтандаа удсан хүндэтгэх шалтгаан байхгүй ч гэсэн та хүүхдийн халамжийн ирээдүйн хариуцлагатай гэрээгээ өөрчилөхийг хүсч болно.
3. ALJ-ийн шийдвэрийн хувилбарыг танруу шуудангаар явуулах болно. ALJ-ийн шийдвэрт таны хөндлөнгийн эрх үүргийн тухай дурьдсан байх болно.
4. DCS нь хуулийн байцаалтанд оруулах хүсэлт авбал тохиромжтой бол хоёр талд хоёуланд нь мэдэгдэх болно. Хоёр тал хоёулаа хуулийн байцаалтанд орох эрхтэй.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл доорхи хаягаар холбогдоно уу:

DIVISION OF CHILD SUPPORT

PO BOX 11520

TACOMA WA 98411-5520

сэтгэлдээ _____ утасдах бүс нутаг _____

Гадны _____ утасдах бүс нутаг _____

TTY/TDD үйлчилгээ ярианы болон сонсголын гажигтай хүн авч болно.

Манай вэб хаяг руу орно уу: www.dshs.wa.gov/esa/division-child-support

Хэн ч арьс өнгө, үүсэл гарал, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хүйс, нас эсвэл тахир дутуу зэргээсээ болж ажил, үйлчилгээ болон ямар нэгэн програмын үйл ажиллагаанаас ялгаварлан гадуурхагдах ёсгүй. Хүсвэл энэ маягыг өөр хувилбараар авч болно.